



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 нэрийн, нийт 36,959,500.00 (гучин зургаан сая есөн зуун тавин есөн мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, 35,792,833.18 (гучин таван сая долоон зуун ерэн хоёр мянга найман зуун гучин гурван төгрөг арван найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий ашиглалтын хугацаа дууссан, дахин үнэлэгдсэн хөрөнгийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, хавсралтад заасны дагуу Архангай, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газарт бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад заасан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагын дарга, Архангай, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006794

2-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн  
41 дүгээр тогтоолын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ДАНСНААС ХАСЧ, ОРОН  
НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д      | Балансад бүртгэлтэй байгууллагын нэр                                      | Хөрөнгийн нэр             | Ашиглалтад орсон огноо | Тоо хэмжээ | Балансын үнэ (төгрөг)                                            | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)                                                                   | Үлдэх өртөг (төгрөг)                                                                     | Хүлээн авах байгууллага                                |
|----------|---------------------------------------------------------------------------|---------------------------|------------------------|------------|------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------|
| 1        | Хан-Хөхийн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа | Land cruiser 100 5133 УВА | 2019.03.04             | 1          | 35,000,000.00                                                    | 33,833,333.18                                                                                    | 1,166,666.82                                                                             | Увс аймгийн орон нутгийн өмчийн газар                  |
| 2        | Галба өөш Долоодын говийн сав газрын захиргаа                             | Мотоцикл Нүүдэлчин        | 2020.10.07             | 1          | 1,959,500.00                                                     | 1,959,500.00                                                                                     | -                                                                                        | Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар |
| Нийт дүн |                                                                           |                           |                        |            |                                                                  |                                                                                                  |                                                                                          |                                                        |
|          |                                                                           |                           |                        |            | 36,959,500.00                                                    | 35,792,833.18                                                                                    | 1,166,666.82                                                                             |                                                        |
|          |                                                                           |                           |                        |            | (гучин зургаан сая есөн зуун тавин есөн мянга таван зуун төгрөг) | (гучин таван сая долоон зуун ерэн хоёр мянга найман зуун гучин гурван төгрөг арван найман мөнгө) | (нэг сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг наян хоёр мөнгө) |                                                        |